

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/221/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Гэрээт аудитор: С.Алтанхундага  
Утас: 70453799, Цахим хаяг: S\_Altanhundaga@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
Асуудлыг онцолсон хэсэг .....	
Аудитын гол асуудал.....	
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	
4.1 Ерөнхий зүйл .....	
4.2 Материаллаг байдал .....	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.5.1 Завсрын аудитын талаар .....	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	
5.1 Залруулсан алдаа .....	
5.2 Төлбөрийн акт .....	
5.3 Албан шаардлага .....	
5.4 Зөвлөмж.....	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч
НА	Нийцлийн аудит



УВС АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Ч.ЧИМЭД ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2022.03.15 № УВА.2023/221/НА.СТА.ТЧЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 22 төсөл арга хэмжээнд 3,538,664.3 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200000050

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink, appearing to read 'М.Батсуурь', is written over a red square official stamp. The stamp contains some illegible text and a central emblem.

М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>251,455,076.39</u>	<u>4,929,434.82</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	251,455,076.39	4,929,434.82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	251,455,076.39	4,929,434.82
31211	Төрийн сангийн харилцах	251,455,076.39	4,929,434.82
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>251,455,076.39</u>	<u>4,929,434.82</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>251,455,076.39</u>	<u>4,929,434.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>251,455,076.39</u>	<u>4,929,434.82</u>
512	Хуримтлагдсан үр дүн	<u>251,455,076.39</u>	<u>4,929,434.82</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	8,948,968.39	251,455,076.39
51220	Тайлант үеийн үр дүн	242,506,108.00	-246,525,641.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>251,455,076.39</u>	<u>4,929,434.82</u>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,691,150,651.00	3,292,138,657.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	176,050,750.00	
120	Нийтлэг татварын бус орлого	176,050,750.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	176,050,750.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	176,050,750.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,515,099,901.00	3,292,138,657.43
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,515,099,901.00	3,292,138,657.43
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,515,099,901.00	3,292,138,657.43
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		20,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		20,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,448,644,543.00	3,538,664,299.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,448,644,543.00	3,538,664,299.00
223001	Бусад хөрөнгө	4,448,644,543.00	3,538,664,299.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>242,506,108.00</u>	<u>-246,525,641.57</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>242,506,108.00</u>	<u>-246,525,641.57</u>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,691,150,651.00	3,292,138,657.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	176,050,750.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	176,050,750.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,515,099,901.00	3,292,138,657.43

131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,515,099,901.00	3,272,138,657.43
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		20,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		20,000,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,691,150,651.00</b>	<b>3,292,138,657.43</b>
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>4,691,150,651.00</b>	<b>3,292,138,657.43</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>4,448,644,543.00</b>	<b>3,538,664,299.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,448,644,543.00</b>	<b>3,538,664,299.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	4,448,644,543.00	3,538,664,299.00
223001	Бусад хөрөнгө	4,448,644,543.00	3,538,664,299.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>4,448,644,543.00</b>	<b>-3,538,664,299.00</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	242,506,108.00	-246,525,641.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,948,968.39	251,455,076.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	251,455,076.39	4,929,434.82

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			8,948,968.39		8,948,968.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			8,948,968.39		8,948,968.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн			242,506,108.00		242,506,108.00

C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			251,455,076.39		251,455,076.39
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			251,455,076.39		251,455,076.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>			<b>251,455,076.39</b>		<b>251,455,076.39</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00		-246,525,641,57		-246,525,641,57
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>4,929,434.82</b>		<b>4,929,434.82</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		251,455,076.39	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,585,688,800.00	3,538,664,299.00	47,024,501.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,585,688,800.00	3,538,664,299.00	47,024,501.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,585,688,800.00	3,538,664,299.00	47,024,501.00
223001	Бусад хөрөнгө	3,585,688,800.00	3,538,664,299.00	47,024,501.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		3,292,138,657.43	
		3,585,688,800.00		293,550,142,57
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,350,203,700.00	3,292,138,657.43	58,065,042.57
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	3,330,203,700.00	3,272,138,657.43	58,065,042.57
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	20,000,000.00	20,000,000.00	
132001	Орон нутгийн төсвөөс	20,000,000.00	20,000,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	235,485,100.00		

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	251,455,076.39
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,929,434.82

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг. Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

1. Төсвийн тухай хууль,
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
6. Малын тоо толгойн албан татварын тухай

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 246,525.7 мянган төгрөгөөр буюу 98.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	251 455.1	4 929.4	-246 525.7
Авлага			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
<b>Нийт хөрөнгө</b>	251 455.1	4 929.4	-246 525.7
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	251 455.1	4 929.4	-246 525.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	251 455.1	4 929.4	-246 525.7

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,929.4 мянган төгрөг болж 246,525.7 мянган төгрөгөөр буурсан нь төсөл арга хэмжээг санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,929.4 мянган төгрөг болж 246,525.7 мянган төгрөгөөр буурсан нь тайланд үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,330,203.7 мянган, орон нутгийн төсвөөс 20,000.0 мянга, нийт зарлагыг 3,350,203.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжих зардлыг 38,065.0 мянган төгрөгийг хасаж 3,272,138.7 мянган төгрөг, орон нутгаас санхүүжих зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр баталсан.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 78,064.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,585,688.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,272,138.7 мянга, төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 20,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,538,664.3 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 47,024.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Итгэлцүүрээр олгох 70106/83401	3,010,679.5	2,971,502.3	39,177.2	
2	Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр 70106/83402	231,596.4	230,636.3	1,633.7	
3	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 70106/83403	87,927.8	81,714.2	6,213.6	
4	Бусад 70106/83406	255,485.1	255,485.1	0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор С.Алтанхундага гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 7/367 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,538,664.3 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 17,693.3 мянган төгрөгөөс гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцож 14,154.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан гэсэн сайт байхгүй Увс аймаг /Засаг дарга/ сайтад Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг /сар бүр

бүтэн жил/-ээр мэдээлэхээр байгаа боловч мэдээлэл оруулаагүй, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг мэдээлсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР 

/С.АЛТАНХУНДАГА/

2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр